

SOCIAL ACCOUNTABILITY ХЭМЭЭХ НЭР ТОМЬЁОГ МОНГОЛООР ОНООХ ТУХАЙ

Д. Амарбаясгаланⁱ

Товч агуулга: Англи хэлний “Social accountability” гэсэн ойлголтыг монгол хэлнээ Нийгмийн хариуцлага, Нийгмийн хариуцан тайлагналт, Иргэдийн хяналт зэрэг олон янзаар орчуулан хэрэглэж байна. Үүний зэрэгцээ “Social responsibility”, “Corporate social responsibility” гэсэн ялгаатай ойлголтууд, мөн Нийгмийн хариуцлага гэсэн ижил нэр томъёогоор орчуулагдан хэрэглэж байгааг залруулах, зөв оноон хэвшүүлэх нь нэн чухал юм. Иймд “Social accountability” гэх ойлголтыг үндсэн үзэл санаа, хэрэглээ, арга хэрэгсэл, төрлүүдийг судлан, нэр томъёоны хувьд давхардсан ойлголтуудтай харьцуулан бичихийг зорилоо. Улмаар хэл шинжлэлийн болон холбогдох чиглэлийн 20 гаруй эрдэмтэн судлаачдын оролцоотой хэлэлцүүлэн, эцэстээ “Нийгмийн эгэх хариуцлага ” гэсэн нэр томъёоны шинэ хувилбарт санал нэгдсэн талаар уг өгүүлэлд танилцуулна.

Түлхүүр үгс: Social accountability, нийгмийн эгэх хариуцлага, иргэний үүрэг оролцоо, нэр томъёоны давхардал

Сүүлийн арав гаруй жил англи хэлний “Social accountability” гэх ойлголтыг монгол хэлнээ “Нийгмийн хариуцлага”, “Нийгмийн хариуцан тайлагналт”, “Иргэдийн хяналт” зэргээр орчуулан ашиглаж буй хэдий ч тухайн ойлголтын нэр томъёоны хувьд санал нэгдээгүй, мөн нэгдсэн тодорхойлолт байхгүй хэвээр байна.

Нийгмийн эгэх хариуцлагынⁱⁱ арга механизм нь иргэн, иргэний нийгмийн байгууллагын (ИНБ) зүгээс шууд болон шууд бус замаар төрд хариуцлага тооцохыг хэлэх бөгөөд төр, хэвлэл мэдээлэл, хувийн хэвшил, хандивлагч байгууллагууд зэрэг оролцогч талуудын хариуцан тайлагнах, хариуцлага тооцох үйл явцтай холбогдох бүхий л үйл ажиллагааг хэлнэ.

1. “Social accountability” ойлголтын тодорхойлолт

Дэлхийн банкны засаглал, Авилгын эсрэг стратегид уг ойлголтыг “иргэд хэр хэмжээнд, ямар чадавхтайгаар төрд хариуцлага тооцох, өөрсдийн хэрэгцээнд нийцэх хариу үйлдлийг төрийн зүгээс хийлгэхийг хэлнэ” (Дэлхийн банк, 2012: 30). Өөрөөр хэлбэл, энэ нь иргэд сонгуульд санал өгөхөөс гадна төрийн хариуцан тайлагнах үйл явцыг нэмэгдүүлэхэд чиглэсэн

үйл ажиллагаа юм. Уг тодорхойлолтоос үзэхэд иргэдийн идэвх, санаачилгын үндсэн дээр эргэх холбоо үүсгэх буюу төрийн зүгээс үйл ажиллагаагаа тайлагнах, шаардлагатай өөрчлөлт хийх гэж ойлгож болно.

Дэлхийн банкны зүгээс нийгмийн эгэх хариуцлага нь төрийн бодлого боловсруулалт, хэрэгжүүлэлтийн үйл явц дахь ил тод, хөнгөн шуурхай байдлыг нэмэгдүүлэн улмаар иргэдийн сайн сайхан аж байдалд шаардлагатай засаглалын хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх арга зам хэмээн үздэг байна. Ингэхдээ төрийн зүгээс иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч тулгамдсан асуудлыг тодорхойлж, тэдгээрийн уг шалтгааныг илрүүлж, улмаар асуудлыг шийдвэрлэх хувилбараас сонгон хэрэгжүүлнэ гэжээ. (Дэлхийн банк, 2015)

Зүүн өмнөд Азид идэвхтэй үйл ажиллагаа бүхий мэргэшсэн байгууллагаас уг ойлголтыг “Зохион байгуулалттай, чадваржсан иргэд төрийн үйлчилгээг сайжруулах, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, иргэдийн эрхийг хамгаалахын төлөө төрийн үйл ажиллагаанд бүтээлчээр оролцож, үр дүнг хянах үйл явц” (ANSA - EAP, 2012) гэж тодорхойлсон нь иргэд шаардлагатай үед эвлэлдэн нэгддэг, төрийн үйл хэргийн талаар шаардлагатай мэдээллийг хүлээн авдаг, оролцоогоо хэрхэн хангах тухай мэдлэгтэй байхыг илүү тодруулсан байна.

Дэлхийн банкнаас дараах үндсэн таван бүрэлдүүлбэрийг тодорхойлж тэдгээрийн харилцан үйлчлэлээр нийгмийн эгэх хариуцлага тодорхойлогдоно гэжээ. (Дэлхийн банк, 2015) Үүнд:

Citizen action - Иргэдийн хариу үйлдэл: Нийгмийн эгэх хариуцлагын гол бүрэлдүүлбэр бөгөөд мэдээлэл, тайлбар хүлээн авах, хариуцлага тооцох; шударга бус үйлдлийг эсэргүүцэх; төрийн үйлчилгээг сайжруулахыг шаардах зэрэг олон төрлийн хэрэглэгч талаас буюу иргэдийн санаачилсан оролцоо, үйл ажиллагааг хамааруулна.

State action - Төрийн хариу үйлдэл: Анхдагч гол бүрэлдүүлбэр, төрийн үйлчилгээг сайжруулах, авилгыг бууруулах зэргээр хийж буй хариу үйлдэл багтана.

Information - Мэдээлэл: Нийгмийн эгэх хариуцлагын зорилгод маш өргөн хүрээний мэдээлэл шаардлагатай бөгөөд мэдээллийг бэлтгэх, олон нийтэд дэлгэх, хэрэглэгчдэд ойлгомжтой хэлбэрт оруулах, мэдээлэл нь бодит, хүртээмжтэй, хэрэглэгдэхүйц байх зэрэгтэй холбогдох хүндрэлийг тооцох шаардлагатай юм.

Citizen – State Interface - Төр - Иргэний харилцаа: Нийгмийн эгэх хариуцлагын үйл явц нь маш цогц ба төр, иргэн гэсэн талуудын хооронд үүсэх иж бүрэн харилцааг хамаардаг.

Citizen mobilization - Олон нийтийн идэвх санаачилга: Нэг талаас, иргэд тэр дундаа эмзэг, орхигдсон бүлгийн “дуу хоолой”-г хүргэхийн тулд идэвх санаачилга шаардлагатай. Нөгөө

талаас, төрийн зүгээс иргэдээ сонсох, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх ажиллагаа шаардлагатай юм.

2. Нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгсэл

Төрийн чиг үүрэг	Үйл явц	Нийгмийн хариуцлагын механизм, арга хэрэгсэл
Бодлого, төлөвлөлт	Оролцооны аргаар бодлого боловсруулах, төлөвлөх	- Орон нутгийн асуудлаар хэлэлцүүлэг хийх - Туршлага судлах - Зөвлөлдөх санал асуулга - Олон нийтийн сонсгол
Төсөв, төсвийн зарцуулалт	Төсөвтэй холбогдох нийгмийн эгэх хариуцлагын үйл ажиллагаа	- Иргэдийн оролцоотой төсвийн төлөвлөлт - Төсвийн хараат бус шинжилгээ - Гүйцэтгэлд тулгуурласан төсөвлөлт - Төсвийн талаарх олон нийтийн боловсрол - Төсвийн зарцуулалтын шинжилгээ
Төрийн үйлчилгээ хүргэх	Төрийн үйлчилгээтэй холбогдох хяналт - шинжилгээ, үнэлгээ	- Олон нийтийн сонсгол - Иргэдийн үнэлгээний / тайлангийн карт - Иргэдийн онооны карт - Олон нийтийн санал асуулга - Олон нийгэд зориулсан мэдээлэл
Олон нийтийн хяналт	Нийгмийн эгэх хариуцлага, олон нийтийн хяналт	- ИНБ - ын хяналтын хороо - Орон нутгийн иргэдийн хяналтын хороо - Омбудсман

Хүснэгт 1: Нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслийн зарим жишээ
(Дэлхийн банк, 2007:5)

Нийгмийн эгэх хариуцлагын арга хэрэгслийн талаар олон эх сурвалжид янз бүрээр ангилан, олон оронд амжилттай туршин нэвтрүүлсэн байна.

Дээр дурдсан арга хэрэгслүүдийг манай орны хувьд ихэнх нь туршин хэрэгжүүлж буй бөгөөд жишээлбэл 2015 онд баталсан Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу эрх зүйн хэм хэмжээг тогтоох, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх, нийтийн эрх ашгийг хөндсөн асуудлын шийдвэрийн төсөл зэрэгт иргэн хүн санал өгөх, мэдээлэл авах боломж нээгдээд байна. Түүнчлэн, Шилэн дансны тухай хуулийг батлан 2015 оноос хэрэгжилтийг хангаснаар

төсвийн шийдвэр, үйл ажиллагааны ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, олон нийтийн хяналтын мэдээллийн тогтолцоог бүрдүүлээд байна.

Мөн Иргэдийн онооны карт, Иргэдийн тайлангийн картын аргуудыг ашиглан Ардчиллын Боловсрол Төвөөс “Check my service” буюу “Манай үйлчилгээг шалга / хяна” санаачилгыг нийт 6 аймгийн 14 сум, нийслэлийн 5 дүүрэгт хэрэгжүүлжээ. Эдгээрт төрийн өмчийн их дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төв, дүүргийн нэгдсэн эмнэлэг, гурав дахь шатлалын эмнэлэг, нутгийн захиргааны байгууллага, нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээ, иргэд хүлээн авах төв зэргийг хамруулан, цаашид Орон нутгийн хөгжлийн сан /ОНХС/-Д иргэдийн хяналтыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. (Ундрал, 2015)

3. “Social accountability” нэр томъёоны хэрэглээ

Уг ойлголтыг монгол хэлнээ нэр томъёоны хувьд *Нийгмийн хариуцлага, Нийгмийн хариуцан тайлагналт, Иргэдийн хяналт* зэргээр ялгаатай хувилбаруудаар орчуулан өргөнөөр хэрэглэн иржээ. Түгээмэл хэрэглээний тухайд, Дэлхийн банк, Швейцарын хөгжлийн агентлаг зэрэг байгууллагуудын төсөл, хөтөлбөрийн баримт бичгүүдэд “Нийгмийн хариуцлага”, “Нийгмийн хариуцан тайлагнах байдал” хэмээн хоёр янзаар авч иржээ. Мөн энэ чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаатай Глоб Интернэшнл төвийн хэрэгжүүлж буй төсөлд “Нийгмийн өмнө хариуцан тайлагнах байдал” буюу “төрөөс төсвийн хөрөнгийг зөв зохистой зарцуулах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахын тулд иргэн, төр хамтран ажиллахыг хэлнэ” гэж тодорхойлсон байна (Глоб Интернэшнл, 2015), Түүнчлэн, “*Иргэдийн хяналт*” буюу албан ёсны хариуцан тайлагнах тогтолцооноос гадна, иргэд, сонирхлын бүлгийн зүгээс бодлого боловсруулах, төсөв батлах, гүйцэтгэлд хяналт тавих зэрэгт оролцон, илүү хариуцлагатай байхыг шаардсан үйл ажиллагаа болохыг нэр томъёоны тайлбарт (Даваадулам, 2010: 10) тэмдэглэжээ.

Зөвхөн “*Accountability*”-ын тухайд тайлбар толь бичигт “Хариуцан тайлагнах” нь хэд хэдэн утгыг илтгэдэг, хариуцлага, хариулах, дагаж мөрдөх, гэм зэмээ хүлээх, үүрэг хүлээх болон тайлагнахтай холбоотой бусад нэр томъёотой ойролцоо утгатай, олон хэлэнд дүйлгэсэн орчуулгагүй байдгийг тэмдэглэжээ (Даваадулам, 2010: 8). Үүнээс гадна “Хариуцан тайлагнах ажиллагаа” нь: 1) *хариуцлага* (төрийн албан хаагчид эрх мэдлийг яаж хэрэгжүүлсэн, хөрөнгийг хэрхэн зарцуулсан, ямар үр дүнд хүрсэн зэрэг асуултад тогтмол хариулж байх); 2) *үр дагавар* (урьдаас тодорхой, утга учиртай гэхдээ энэ нь заавал шийтгэл хүлээлгэх, хөрөнгө мөнгө, хувь хүнтэй холбоотой байх гэсэн үг биш) гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй гэжээ. Засгийн

газрын байгууллага эрх мэдэл, хөрөнгө мөнгийг хэрхэн ашигласан, улмаар хүрсэн үр дүнгийн талаар нийтэд тайлагнах шаардлагатай байдаг учраас захиргааны хариуцан тайлагнах дотоод тогтолцоо нь үйлчилгээг хэрэглэгчид, иргэдийн санал хүсэлтийг тусган хариуцан тайлагнах гадаад тогтолцоотой хамтран үйлчилснээр бүрэн хэрэгжинэ гэжээ. (Шиаво- Кампо., Сундарам, 2000)

Нэр томъёоны хувьд онцлон анхаарах дараагийн асуудал бол “*social responsibility*”, “*corporate social responsibility*” гэсэн ойлголтууд эх хэлэнд “нийгмийн хариуцлага” хэмээн томъёологдон өргөн хүрээнд ашиглагдан хэвшсэн байна. Тухайлбал: “*Social responsibility*” буюу “Нийгмийн хариуцлага” бол “нийгэм, хүрээлэн байгаа орчин, амьдрах чадвартай эдийн засаг гурвын тэнцвэрийг хангахад чиглэгдсэн байгууллагын байр суурь, зан үйл юм. Үүний тулд байгууллага сонирхогч бүх талуудтай мэдээлэл солилцож, нээлттэй, ил тод үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээнэ”. Мөн “*Corporate social responsibility*” гэсэн ойлголтыг “Компанийн нийгмийн хариуцлага” хэмээн томъёолж, энэ нь нийгмийн тогтвортой хөгжилд бизнесийн хүрээнийхний оруулж буй нийт хувь нэмэр бөгөөд аливаа баялгийг бүтээх, үйлдвэрлэлийн хаягдлыг хянах, ажиллагчид даа анхаарал халамж тавих, зар сурталчилгааг шударгаар хийх, ил тод байх зэрэг компанийн үйл ажиллагааны үр дүнгийн олон үзүүлэлт багтдаг” гэж тодорхойлсон Оросын эрдэмтэн Ю.Смагринскийг эш татжээ (Шуурав, 2008: 8-10).

Англи хэлний зарчмын ялгаатай “*Responsibility*” болон “*Accountability*” нь “Хариуцлага” гэсэн нэг нэр томъёогоор оруулж байгааг тайлбарлахад дараах тодорхойлолт дөхөм болох болов уу. Учир нь “*Responsibility*” - Хариуцлага буюу хууль, улс төр, эдийн засгийн маш өргөн утгыг илтгэдэг нэр томъёо бөгөөд төрийн захиргаанд түүний гурван үндсэн, ялгаатай төрлүүдийг тэмдэглэсэн байна: Үүнд: нэгдүгээрт, *responsibility as “capacity”* - хариуцлага “чадавх” болох талаасаа төрийн албан хаагч аливаа үйлдэл хийх чадавх, эсвэл эрх мэдэл; хоёрдугаарт, *responsibility as “accountability”* - хариуцлага “хариуцан тайлагнах” ажиллагаа болох утгаар төрийн албан хаагчид албан үүргээ гүйцэтгэсэн үр дүнгийн талаар захиргааны дотоод, эсвэл түүний гаднах эрх барих байгууллагад мэдээлэх, тайлбар, үндэслэл гаргах үүргийг илэрхийлдэг; гуравдугаарт, *responsibility as liability*” - хариуцлага “хариуцлага хүлээлгэх” ажиллагаа болох талаас, хэн нэгэн өөрийн хийсэн үйлдэл болон заримдаа тухайн үйлдэл нь эцсийн хариуцлага хүлээх албан тушаалтны эрх мэдлийн хүрээнд хийгдсэн бол бусдын хийсэн үйлдлийн үр дагаврыг хариуцна гэсэн үг. Хариуцлагад мөн хууль бус,

нийтийн ашиг сонирхолд харшилсан үйлдэл хийхээс татгалзах ёс суртахууны үүрэг багтана (Даваадулам, 2010:98-99).

Харин “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь”-д “*Хариуцлага*” гэдэг үгийг “хариуцах үйлийн нэр, ажил үүргийг биедээ хүлээсэн нь” гэж тодорхойлсон байна (Болд, 2008: 2470).

4. Нэр томъёоны шинэ хувилбар

Уг ойлголтыг эх хэлнээ нэн даруй “зөв” томъёолон хэвшүүлэх шаардлагатай гэж дүгнээд төрийн удирдлага, менежмент, хэрэглээний хэл шинжлэлийн эрдэмтэн судлаачид, Иргэний нийгмийн болон олон улсын байгууллагын төлөөллийг оролцуулан хоёр удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж дараах шинэ нэр томъёог оноон хэвшүүлэхээр санал нэгдсэн болно.

Хэлэлцүүлгийн явцад “Responsibility”, “Accountability” гэсэн ойлголтуудыг ялгах нь зүйтэй гээд цаашид “Responsibility” = “Хариуцлага” хэмээн ашиглах тухайд санал нэгдсэн юм. Харин “Accountability” гэсэн ойлголтыг талаар нэр томъёоны олон хувилбар дэвшүүлж тэдгээрийн үндэслэлийг ярилцсаны эцэст хэл шинжлэлийн доктор Н.Мөнхцэцэг, О.Шинэбаяр нарын гаргасан “Эгэх хариуцлага” хэмээх нэр томъёоны саналыг дийлэнх олонх дэмжин цоо шинээр “Social Accountability” буюу “Нийгмийн эгэх хариуцлага” хэмээн хэрэглэн хэвшүүлэхээр шийдвэрлэсэн юм.

Монгол хэлний товч тайлбар тольд “эгэх” хэмээх нэршсэн үйл үгийн утгыг “хойш буцах, эргэх” хэмээн (Цэвэл, 2013: 1200) тайлбарласан

бол дэлгэрэнгүй тайлбар тольд (Болд, 2008: 3175) “эгэх” - хойш буцах, арагшаа ухрах; эгэж ирэх (буцаж ирэх), эгэн суух (босох гэснээ больж буцан суух) гэжээ. Нэгэнт уг ойлголтын хувьд иргэн - төр гэсэн хоёр талуудын хооронд үүсэх иж бүрэн харилцааг тодорхойлдог тул үгийн утгын хувьд тохирохуйц, бусад ойлголтуудаас ялгарахуйц хэмээн үзсэн. Одоо гагцхүү, энэхүү шинэ нэр томъёог албан ёсоор баталгаажуулах, холбогдох оролцогч талуудад таниулах, нийтийн дунд хэвшүүлэх нь чухал шаардлагатай юм.

Ном зүй

Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Уб., Соёмбо принтинг ХХК. 2008. 3278 х.

Глоб Интернэшнл. 2015. “Боловсролын салбар дахь ил тод ба хариуцан тайлагнах байдал” төслийн танилцуулга.

Даваадулам, Ц. 2010. Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг. Уб., 114 х.

Ундрал, Г. 2015. “Check my service” илтгэл, Улаанбаатар, Ардчиллын Боловсрол Төв.

Цэвэл, Я. 2013. Монгол хэлний товч тайлбар тал. Уб., 1311 х.

Шиаво - Кампо, С., Сундарам, П. 2011. Иргэддээ үйлчилж, төрт ёсны үнэт зүйлсээ хадгалах: Өрсөлдөөнт ертөнцөд төрийн захиргааг сайжруулах нь, Уб., Адмон ХХК. 364 х.

Шуурав, Я. 2008. Компаний нийгмийн хариуцлага: ойлголт, хүрээ, хэрэгжүүлэх арга зам. Уб., Удирдлагын Академи.

ANSA - EAP 2012. Social accountability perspectives and practices in East Asia and the Pacific: Social accountability stocktaking reports, Mongolia.

World Bank 2015. *Opening the Black Box: Contextual Drivers of Social Accountability Effectiveness.*

World Bank 2012. Strengthening Governance, Tackling Corruption: The World Bank’s Updated Strategy and Implementation Plan, Washington.

World Bank. 2007. *Social accountability: Strengthening the Demand Side of Governance and Service Delivery.* (retrieved: <http://www.-esd.worldbank.org/sac/>)

ⁱ Удирдлагын академийн багш

ⁱⁱ Энэ өгүүлэлд ШУА - ийн Хэл зохиолын хүрээлэнгийн ЭШАА доктор (Ph.D) О.Шинэбаяр, доктор (Ph.D) Н.Мөнхцэцэг нарын оноосон “Нийгмийн эгэх хариуцлага” гэсэн нэр томъёоны шинэ хувилбарыг хэрэглэв.